

14 хоногийн шуурхай мэдээ

Төсвийн байгууллага, ОНӨААТҮГ, төсөл хөтөлбөр, сангийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудитыг 2021оны 09 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд Д.Ихбаяр ахлах аудитаар ахлуулсан ажлын хэсэг ирж ажиллалаа.

Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр “Цацын амна ус” хэмээх газарт нутаглах малчны суурьт мал, амьтны гоц халдварт Шүлхий өвчний сэжигтэй шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан нийт малчид, иргэдэд урьдчилан сэргийлж анхаруулан голомтын бүсэд 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэм тогтоон 24 цагийн пост ажиллуулж байна.

2021.09.08-ны өдөр Тэргүүлэгчид хуралдан ИТХ-ын ээлжит дөрөвдүгээр хуралдааны товыг 2021оны 09 сарын 27-ны өдөр хуралдахаар тогтоолоо.

Мал эмнэлгийн тасаг

Говь-Угтаал сумын Морьт багийн нутаг Сацын амна ус / 46°16'33.29, 107°15'15.23, 46°19'21.05, 107°14'17.96/ нутагт шүлхий өвчний голомт үүссэн тул аймгийн мал эмнэлгийн газарв хүсэлт тавьж 13000 тун вакцин татан авч шүлхий өвчний голомтот байгаа 8 өрхийн 12493 малыг дархлаажуулаад байна.

Газрын алба

2022 оны өмчлөлийн газар зохион байгуулалтын хүсэлтийн ИТХ-д хүргүүллээ.

Фото мониторингийн боловсруулалт ба тайлангийн ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 9-ны өдөр хийж гүйцэтгэн ажиллаа.

Хөдөлмөр халамж үйлчилгээ

Ургац хураалтанд 5 иргэн Төв аймгийн Борнуур сумруу явлаа. Хүнсний эрхийн бичиг авдаг өрхийн хөдөлмөрийн насны 3-н иргэнийг хамруулсан.

Амьжиргаа дэмжих зөвлөлд 2 ахмад настны асаргаа, хүнсний эрхийн бичиг авдаг 2 өрхийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Эрүүл мэндийн төв

Голомтонд 0, урьдчилан сэргийлж 80 м2 нийт 80 м2 газарт ариутгал халдваргүйжүүлэлт хийгдлээ.

Сургууль, Цэцэрлэгийн багш ажилчидад нийт 85 хүнд түргэвчилсэн оношлуураар шийнжилгээ хийсэн.

Ойрын хавтал 6 дан хавтал 12 нийт 18 иргэний гэрийн тусгаарлалтанд авч хяналт тавьж шинжилгээ хийж ажиллаа.

55наснаас дээш, архаг хууч өвчтэй иргэний 2 ба 3 тунгийн вакциныг 43 хүнд, товлолын вакциныг 12 хүүхдэд тус тус хийсэн.

Цэцэрлэг, байрны 60 хүүхдүүдэд цагаан хорхойны шинжилгээ хийсэн.

ЭМГ- аас Ковидын 3-р тун вакцины талаар, ковид – 19 цаг үеийн байдалтай холбоотой цахим сургалтанд эмч мэргэжилтэн хамрагдлаа.

Хүүхдийн цэцэрлэг

09 дүгээр сарын 01-нд 4-5 настай хүүхдүүдийг хүлээн авч халдвар хамгаалалтын дэглэмийг чанд мөрдөн ажиллаж байна .

Багш нар “Суралцагчидын хоцрогдолыг арилгах” сургалтын хөтөлбөр төлөвлөөг гаргаж ажиллаа.

Эрхлэгч Дундговь Аймгийн Багш нарын 73 дахь бага хуралд сууж 2021-2022 оны хичээлийн жилийн зорилго зорилтыг дэвшүүллээ.

Багш ажилчид цэцэрлэгийн гадаа цэцэгийн мандалын хашаа барьж, жижүүрүүд гадаа хогийн пүнкер шавардлан дээвэрт нөхөөс хийлээ.

Биеийн тамирын зал ,оо-ын өрөөнд үйлчлэгч их цэвэрлэгээ хийлээ.

Соёлын төв

Яруу найрагч Б.Доржпаламын нэрэмжит нийтийн номын санд Хамтын хүч ХХК жил бүр 150,000 төгрөгний хандив өргөж номын сангийн шилдэг тэргүүний уншигчийг шалгаруулж шагнаж хэвшсэн. 2020-2021 оны шилдэг сурагчаар 7а ангийн сурагч О. Тэлмүүн, 4а ангийн сурагч А. Хүслэнзаяа , 1-р ангийн сурагч Б. Бадамсамбуу нар шалгарлаа.

Дундговь аймгийн ахмадын урлагийн 7-р бага наадамд ахмадуудыг бэлтгэн оролцож багаараа зүүн бүсдээ 3-р байр эзэллээ.

Бүсээс Монгол ардын бүжгийн төрлөөр МУТУС Ш.Мөнхцэцэг 1-р байр, Гоцлол хөгжмийн төрөлд МУТАА Д.Сайнхүү 1-р байр, Ардын дууны төрөлд МУТАА Б.Хонинхүү 2-р байр, Язгуур урлаг 3-р байр, Уран уншлага Г.Нямзав 2-р байр, Дуэт дуу Б. Воля С.Нэмэхжаргал, 2-р байр, Хамтлаг хөгжим 3-р байр тус тус эзэлсэн амжилтыг үзүүллээ.

Ерөнхий боловсролын сургууль

Дундговь аймгийн БСУГ, ЭМГазартай хамтран зохион байгуулсан Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд Сургалтын менежер, Бага ангийн багш нар, Номын санч, Үдийн цай, Дотуур байрны тогооч нар хамрагдлаа.

Хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах ажлыг байгуулан бэлтгэлийг ханган хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Аймгийн Хүүхэд, Гэр бүл хөгжлийн газраас зохион байгуулсан Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалтанд БНАжилтан хамрагдлаа.

Сургуулийн ангиуд эцэг эхчүүдийн хурал хийж, эцэг эх харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулан ажиллаа.

Сургуулийн захирлын тушаалаар Сургуулийн дотоод хяналтийн нэгж шинээр байгуулагдан ковидын үед сургууль, эцэг эх, сурагчдын дагаж мөрдөх зөвлөмжийг боловсруулан гаргаж байршуулав.

Сургуулийн дотуур байр байранд суух сурагчдыг бүртгэн хүлээн авч орууллаа.

Багш нар судлагдахуун тус бүрээр гараа үнэлгээний шалгалтын материал боловсруулан гараа үнэлгээг тогтоож байна.

ТАЙЛАН БИЧСЭН

АРХИВ,БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Г.АМАРБАЯР

ХЯНАСАН

ЗДТГАЗРЫН ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГТОХ

